



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ*

2020 оны 8 дугаар сар

Ерөнхий тойм:


Энэ оны эхний 8 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 16%-иар буюу 1,546 сая ам.доллараар буурч 7,932 сая ам.доллар байв. Үүнд экспорт 17%-иар буюу 908 сая ам.доллараар, импорт 16%-иар буюу 638 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 270 сая ам.доллараар буурч 1,026 сая ам.долларын ашигтай гарлаа.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 8 сар			Өөрчлөлт			
	2017	2018	2019	2018/2017		2019/2018		2018	2019	2020	2019/2018		2020/2019	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	10,538	12,887	13,747	2,349	22%	861	7%	8,473	9,478	7,932	1,005	12%	(1,546)	-16%
Экспорт	6,201	7,012	7,620	811	13%	608	9%	4,671	5,387	4,479	716	15%	(908)	-17%
Импорт	4,337	5,875	6,128	1,537	35%	253	4%	3,802	4,091	3,453	289	8%	(638)	-16%
Тэнцэл	1,863	1,137	1,492	(726)		355	31%	869	1,296	1,026	427	49%	(270)	-21%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл** 2020 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 187 сая ам.доллараар буурч, 1,175 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/



Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 56% буюу 4,412 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 12% буюу 957 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 18%-иар, БНХАУ-тай хийсэн худалдаа 28%-иар буурлаа.

* Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.

** Нийт худалдааны дүнгээс дахин экспорт/импорт, боловсруулах бараа, бараа солилцоо, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа

Экспорт: 2020 оны эхний 8 сарын гүйцэтгэл өнгөрсөн оны мөн үеэс 17%-иар буюу 908 сая ам.доллараар буурав. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт буурсан нь нийт экспортыг 11 нэгж хувиар бууруулах чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 5 нэгж хувиар өссөн бол мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 3 нэгж хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2018			2019			2020			Δ (2019/2018)			Δ (2020/2019)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%²	Дүн	Өсөлт	%²
1. Уул уурхай		4,122	88%		4,761	88%		4,171	93%	639	15%	14%	(589)	-12%	-11%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	960	1,328	28%	982	1,329	25%	905	1,011	23%	1	0%	0%	(318)	-24%	-6%
1.2. Чулуун нүүрс	23,487	1,837	39%	24,924	2,132	40%	15,175	1,167	26%	295	16%	6%	(965)	-45%	-18%
1.3. Боловсруулагүй нефть	4,388	287	6%	4,290	241	4%	1,831	67	1%	(46)	-16%	-1%	(174)	-72%	-3%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	4,591	210	5%	5,554	379	7%	5,589	402	9%	168	80%	4%	24	6%	0%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	3,432	144	3%	7,464	344	6%	19,934	1,147	26%	200	138%	4%	802	233%	15%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	81	138	3%	91	132	2%	89	106	2%	(6)	-4%	0%	(27)	-20%	0%
1.7. Жош, лейцит, нефелинт	289	97	2%	421	132	2%	428	101	2%	35	36%	1%	(31)	-23%	-1%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	4	32	1%	4	33	1%	4	27	1%	1	3%	0%	(5)	-17%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	0	4	0%	0	4	0%	0	0	0%	(0)	-3%	0%	(4)	-96%	0%
1.10. Мөнгө /тонн/	0	1	0%	0	-	0%	175,697	96	2%	(1)	0%	0%	96	0%	2%
1.11. Бусад	330	43	1%	102	35	1%	40	47	1%	(8)	-19%	0%	13	36%	0%
2. Мал аж, ахуй	271	357	8%	232	383	7%	156	186	4%	26	7%	1%	(197)	-52%	-4%
2.1. Амьд мал, малын мах	16	36	1%	17	33	1%	6	13	0%	(2)	-7%	0%	(21)	-62%	0%
2.2. Арьс, шир	235	12	0%	196	11	0%	138	6	0%	(2)	-14%	0%	(5)	-44%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	5	0%	0	5	0%	0	6	0%	0	3%	0%	1	14%	0%
2.4. Ноолуур	8	285	6%	8	317	6%	6	155	3%	32	11%	1%	(162)	-51%	-3%
2.5. Ноос, бусад үс, хялгас	10	17	0%	8	15	0%	5	6	0%	(3)	-15%	0%	(9)	-62%	0%
2.6. Бусад	1	2	0%	3	2	0%	0	1	0%	(0)	-7%	0%	(1)	-69%	0%
3. Газар тариалан	24	5	0%	32	7	0%	28	7	0%	2	52%	0%	0	2%	0%
4. Аж үйлдвэрлэл	171	187	4%	291	236	4%	168	114	3%	49	26%	1%	(122)	-52%	-2%
4.1. Хүнс	14	42	1%	16	41	1%	9	26	1%	(2)	-4%	0%	(15)	-37%	0%
4.2. Ноолууран эдлэл	0	19	0%	1	25	0%	0	19	0%	6	31%	0%	(6)	-24%	0%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	2	9	0%	2	9	0%	3	9	0%	(0)	-1%	0%	0	0%	0%
4.4. Уул уурхай	35	73	2%	105	71	1%	12	39	1%	(2)	-3%	0%	(32)	-4%	-1%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	2	0%	0	1	0%	0	1	0%	(1)	-71%	0%	(0)	-10%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	2	38	1%	1	85	2%	1	17	0%	47	126%	1%	(68)	-80%	-1%
4.7. Бусад	118	3	0%	166	4	0%	142	3	0%	1	36%	0%	(2)	-34%	0%
5. Бусад	0	1	0%	0	1	0%	0	1	0%	(0)	-25%	0%	0	16%	0%
Нийт дүн		4,671		5,387			4,479			716	15%		(908)	-17%	

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 3. Экспортын өөрчлөлт, 2020 оны эхний 8 сар

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	(184)	%	(405)	%	(589)	%
1. Уул уурхай	(184)		(405)		(589)	-12%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	(85)	27%	(232)	73%	(318)	-24%
1.2. Чулуун нүүрс	(750)	78%	(215)	22%	(965)	-45%
1.3. Боловсруулагүй нефть	(90)	51%	(84)	49%	(174)	-72%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	3	11%	21	89%	24	6%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	717	89%	85	11%	802	233%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	(2)	8%	(24)	92%	(27)	-20%
1.7. Жош, лейцит, нефелинт	2	-5%	(33)	105%	(31)	-23%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	3	-50%	(8)	150%	(5)	-17%
1.11. Бусад	(74)	-586%	86	686%	13	36%
2. Мал аж, ахуй	(62)	31%	(135)	69%	(197)	-52%
2.1. Амьд мал, малын мах	(21)	103%	1	-3%	(21)	-62%
2.2. Арьс, шир	(3)	55%	(2)	45%	(5)	-44%
2.4. Ноолуур	(28)	17%	(134)	83%	(162)	-51%
3. Газар тариалан	(1)	-757%	1	857%	0	2%
4. Аж үйлдвэрлэл	(317)	259%	195	-159%	(122)	-52%
5. Бусад	(0)	-460%	0	45%	0	16%
Нийт дүн	(564)		(344)		(908)	-17%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.


2020 оны эхний 8 сарын гүйцэтгэлийг өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулж, нийт 908 сая ам.долларын бууралтыг харвал:

1/ Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 184 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 405 сая ам.доллараар буурчээ.

Үүнд чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ болон үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 1,283 сая ам.доллар болж буурахад голлон нөлөөлсөн. Харин алтны экспорт тоо хэмжээний өсөлттэй холбоотойгоор өнгөрсөн оны мөн үеэс 802 сая ам.доллараар өссөн.

2/ Мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын хувьд биет хэмжээний бууралтаас шалтгаалж 62 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалан 135 сая ам.доллараар буурсан.

Зураг 3. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2020 оны 8 дугаар сард 1,970 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 31%-иар, өмнөх сараас 7%-иар өслөө. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 6,499; 121 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 14%-иар, төмрийн хүдэр 30%-иар тус тус өссөн.

Харин өмнөх сартай харьцуулбал, зэсийн үнэ болон төмрийн хүдэр 2%, 12%-иар тус тус өсчээ. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 8 дугаар сард 72 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 13%-иар, өмнөх сараас 2%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 4. Экспортын голлох бүтээгдэхүүний биет хэмжээний өөрчлөлт

Төрөл /мянган тонн/	Эхний 8 сар			Өөрчлөлт		2020				Өөрчлөлт			
	2018	2019	2020	2020/2019		6 дүгээр сар	7 дугаар сар	8 дугаар сар	7 сар/6 сар		8 сар/7 сар		
				Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь	
Чулуун нүүрс	23,487	24,924	15,175	(9,749)	-39%	2,362	2,556	3,966	193	8%	1,410	55%	
Зэсийн баяжмал	960	982	905	(76)	-8%	120	118	111	(1)	-1%	(7)	-6%	
Төмрийн хүдэр	4,591	5,554	5,589	35	1%	675	780	685	104	15%	(95)	-12%	

Зураг 4. Экспортын барааны биет хэмжээний сарын өөрчлөлт



Энэ оны эхний 8 сарын байдлаар экспортын барааны биет хэмжээний сарын өөрчлөлтийг харвал:

- чулуун нүүрсний экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 39%-иар буурч 15,175 мянган тонн,
- зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ 8%-иар буурч 905 мянган тонн,
- төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ 0.6%-иар өсч 5,589 мянган тоннд тус тус хүрчээ.

Импорт: Импорт 2020 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 16%-иар буюу 638 сая ам.доллараар буурав. Импортын 16 нэгж хувийн бууралтыг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 6 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 6 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний бууралт 3 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 5. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2018			2019			2020			Δ (2019/2018)			Δ (2020/2019)			
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²	
Хэрэглээний бүтээгдэхүүн		1,055	28%		1,104	27%		974	28%		49	5%	1%	(130)	-12%	-3%
Түргэн эдэглэгээтэй	640	550	14%	584	549	13%	615	551	16%	(1)	0%	0%	2	0%	0%	
Хүнс	308	381	10%	278	387	9%	298	386	17%	5	1%	0%	(0)	0%	0%	
Эм, пвриа	2	74	2%	2	68	2%	2	71	2%	(7)	-9%	0%	3	5%	0%	
Бусад түргэн эдэглэгээтэй бараа	330	94	2%	304	95	2%	314	94	3%	0	0%	0%	(1)	-1%	0%	
Удаан эдэглэгээтэй	158	505	13%	224	555	14%	203	423	12%	50	10%	7%	(132)	-24%	-3%	
Гутал, хуецац, цунх	39	46	1%	46	42	1%	57	42	1%	(4)	-8%	0%	(0)	-1%	0%	
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба төвлөг	71	75	2%	122	72	2%	88	67	2%	(3)	-4%	0%	(6)	-8%	0%	
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	1	332	9%	1	383	9%	1	254	7%	51	15%	7%	(129)	-34%	-3%	
Бусад удаан эдэглэгээтэй бараа	48	53	1%	55	58	1%	57	61	2%	5	10%	0%	3	4%	0%	
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	1,053	1,532	40%	887	1,763	43%	971	1,520	44%	231	15%	6%	(243)	-14%	-6%	
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	20	951	25%	19	1,162	28%	24	937	27%	211	22%	6%	(225)	-19%	-5%	
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	1	307	8%	2	422	10%	6	333	10%	115	37%	3%	(89)	-21%	-2%	
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	19	644	17%	17	740	18%	18	604	17%	96	15%	3%	(136)	-18%	-3%	
Барилгын материал	538	445	12%	691	459	11%	883	410	12%	14	3%	0%	(49)	-11%	-1%	
Хөрөнгө оруулалтын бусад бараа	27	136	4%	32	142	3%	82	173	5%	6	4%	0%	31	22%	1%	
Аж үйлдвэрлэлийн орц	1,036	500	13%	1,226	448	11%	1,190	429	12%	(52)	-10%	-1%	(19)	-4%	0%	
Хүнсний орц	268	72	2%	35	16	0%	141	37	1%	(56)	-78%	-1%	21	130%	1%	
Химийн бүтээгдэхүүн	139	83	2%	155	81	2%	130	74	2%	(2)	-3%	0%	(7)	-9%	0%	
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	50	19	1%	55	19	0%	46	16	0%	0	0%	0%	(3)	-18%	0%	
Цахилгаан эрчим хүч	1	95	2%	1	95	2%	1	93	3%	1	1%	0%	(3)	-3%	0%	
Металлын хүдэр, баяжмал болон хаяг дал	0	0	0%	1	0	0%	1	1	0%	(0)	-5%	0%	0	15%	0%	
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	595	231	6%	640	236	6%	653	209	6%	5	2%	0%	(27)	-11%	-1%	
Нефтийн бүтээгдэхүүн	1,036	710	19%	1,226	772	19%	1,190	527	15%	62	9%	2%	(245)	-32%	-6%	
Дизель түлш	553	361	10%	745	460	11%	644	274	8%	99	27%	3%	(186)	-40%	-5%	
АИ-92, АИ-95	235	165	4%	320	193	5%	338	141	4%	28	17%	1%	(52)	-27%	-1%	
А-80 болон бусад	248	183	5%	161	118	3%	208	111	3%	(65)	-35%	-2%	(7)	-6%	0%	
Бусад	12	5	0%	4	4	0%	168	3	0%	(1)	-18%	0%	(1)	-22%	0%	
Нийт дүн		3,802			4,091			3,453		289	8%		(638)	-16%		

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 6. Импортын өөрчлөлт, 2020 оны эхний 8 сар /сая ам. доллар/

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Үнийн	%	Нийт	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	(90)	69%	(40)	31%	(130)	-12%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэх	291	-120%	(534)	220%	(243)	-14%
Аж үйлдвэрлэлийн орц	13		(32)		(19)	-4%
Нефтийн бүтээгдэхүүн	(10)	4%	(235)	96%	(245)	-32%
Дизель түлш	(43)	23%	(143)	77%	(186)	-40%
АИ-92, АИ-95	8	-15%	(59)	115%	(52)	-27%
А-80 болон бусад	25	-351%	(32)	451%	(7)	-6%
Бусад	3		(4)		(1)	-22%
Нийт дүн	207	-32%	(845)	132%	(638)	-16%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

2020 оны эхний 8 сарын гүйцэтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нийт импорт 638 сая ам.доллараар буурчээ. Үүнд:

- Машин, механик тоног төхөөрөмжийн буюу хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 243 сая ам.доллараар,

- Дизель түлшний хэрэглээтэй холбоотойгоор нефтийн бүтээгдэхүүний импорт 245 сая ам.доллараар,


- Хэрэглээний бүтээгдэхүүний импорт 130 сая ам.доллараар,
- Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний импорт 19 сая ам.доллараар тус тус буурчээ.

Зураг 5. Импортын жилийн өсөлт / 3 сарын гулсах дундаж/



Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2020 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 33 хувиар буурсан хэдий ч өмнөх сараас 13 хувиар өсч тонн тутамд 415 ам.долларт хүрэв.

Зураг 6. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Гадаад худалдааны нөхцөлийн индекс: 2020 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 4%-иар, өмнөх сараас 0.4%-иар буурч 1.926-д хүрлээ. Худалдааны нөхцөлийн индекс өмнөх оны мөн үеэс буурахад нефтийн бүтээгдэхүүний импортын үнэ болон чулуун нүүрсний экспортын үнэ буурснаар тайлбарлагдаж байна. Харин өмнөх сараас буурахад хөрөнгө оруулалтын барааны импортын үнэ болон чулуун нүүрсний экспортын үнийн бууралтаас голлон шалтгаалжээ.